

## БАНК БУС САНХҮҮГИЙН ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхлэх этгээдэд тавигдах шаардлагыг тодорхойлох, итгэлцлийн үйлчилгээнд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулах, үйл ажиллагаанд хяналт тавихад оршино.
- 1.2. Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч нь энэхүү журам болон холбогдох бусад хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актыг дагаж мөрдөнө.
- 1.3. Итгэлцлийн үйлчилгээг Санхүүгийн зохицуулах хорооноос (цаашид “СЗХ” гэх) тавьсан шаардлагыг хангаж тус үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрөл авсан банк болон банк бус санхүүгийн байгууллага (цаашид “ББСБ” гэх) эрхэлнэ.
- 1.4. Итгэлцлийн үйлчилгээнд талууд бие биедээ харилцан итгэх, үнэнч байх, эрх тэгш шударга байх, хариуцлага хүлээх зэрэг үндсэн зарчмуудыг баримтална.

### ХОЁР. ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1. Итгэлцлийн үйлчилгээ эрхлэхэд дараах шаардлагыг хангасан байх:
  - 2.1.1. Банк болон банк бус санхүүгийн үйл ажиллагааг гурваас доошгүй жил тогтвортой явуулсан, сүүлийн гурван жилийн хугацаанд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээж байгаагүй, сүүлийн дөрвөн улирал дараалан зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж, ашигтай ажилласан байх;
  - 2.1.2. СЗХ-оос итгэлцлийн үйлчилгээ эрхлэх ББСБ-уудад тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан байх;
  - 2.1.3. Сүүлийн дөрвөн улирлын чанаргүй зээлийн багц нь салбарын дунджаас ихгүй байх
  - 2.1.4. Нэг буюу түүнээс дээш тооны хараат бус, нийт таваас доошгүй гишүүн бүхий төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) -тэй байх;
  - 2.1.5. Энэ журмын 2.1.1-т заасан ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хуулийн 75.8-д заасны дагуу компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх;
  - 2.1.6. Итгэлцлийн хөрөнгийн удирдлагын шийдвэр гаргах эрх бүхий этгээдүүд нь өөр ямар нэг албан тушаал давхар хашихгүй байх;
  - 2.1.7. Хөрөнгийг удирдах туршлага бүхий, эрсдэлийн үнэлгээ, активын удирдлагын суурь тооцооллыг хийх чадвартай, санхүү, хөрөнгө оруулалт эсхүл хууль эрх зүйн салбарт таваас доошгүй жил ажилласан туршлагатай нэгээс доошгүй мэргэшсэн боловсон хүчин, хүний нөөцтэй байх;
  - 2.1.8. Хөрөнгө итгэмжлэн удирдахтай холбоотой журам, заавартай байх;
  - 2.1.9. Итгэл хүлээлгэгчийн актив хөрөнгийг итгэлцэл үйлчилгээний хүрээнд ашиглах, захиран зарцуулах доод хугацаа 6 сараас доошгүй, нэг удаагийн гэрээгээр

итгэлцлээр удирдах хөрөнгийн доод хэмжээ 10,000,000 (арван сая) төгрөг ба түүнтэй тэнцэх хэмжээний валют байх;

2.1.10. Итгэлцлээр хүлээн авсан нийт хөрөнгийн тавиас доошгүй хувийг зээлд оруулсан бол итгэлцлийн үйлчилгээ үзүүлэгч ББСБ нь Зээлийн удирдлагын хороотой байна.

2.1.11. Зээлийн удирдлагын хороо нь зээлдэгч бүрийн зээлжих чадварыг дангаар нь эсхүл зээлийн багцаар нь бизнесийн үйл ажиллагаа, аж ахуйн нэгж болон хувь хүн тус бүрээр нь хяналт, үнэлгээ, шинжилгээ хийнэ.

2.1. Банк, ББСБ нь итгэл хүлээлгэгчтэй байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу тэдгээрийн актив хөрөнгийг зохицуулагч байгууллагаас зөвшөөрсөн Банкны тухай болон Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагааны хүрээнд удирдана.

### ГУРАВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Өөрийн хөрөнгийг итгэмжлэгдсэн өмчлөгчийн өмчлөлд шилжүүлж, түүнээс гарах үр шимийг өөрөө хүртэх, эсхүл хувь хүртэгчид хүртээх зорилго бүхий иргэн, хуулийн этгээд буюу “итгэмжлэгч” нь дараах эрхийг эдэлнэ:

3.1.1. Хөрөнгө итгэмжлэх гэрээг бичгээр байгуулах бөгөөд Иргэний хуулийн 406.3-т заасны дагуу итгэмжлэгч гэрээнээс үүсэх аливаа эрсдэлийг хүлээж, үр шимийг хүртэнэ.

3.1.2. ~~Итгэлцлийн үйлчилгээг авах зорилгоор~~ тухайн ББСБ-ын санхүүгийн байдал, итгэлцлийн үйлчилгээний нөхцөл, шаардлага бусад мэдээлэлтэй танилцах;

3.1.3. Итгэлцлийн үйлчилгээний гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш итгэмжлэгдсэн хөрөнгийг захиран зарцуулах үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох бүртгэл тайлан мэдээг шаардах;

3.1.4. Итгэлцлийн үйлчилгээний гэрээгээр тогтоосон үр шимийг хүртэхээр шаардах;

3.1.5. Итгэлцлийн үйлчилгээний гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

3.1.6. Итгэлцлийн үйлчилгээний гэрээнээс үүдэн гарсан аливаа маргаантай холбоотойгоор шүүхэд нэхэмжлэл гаргах.

3.2. Итгэмжлэгч нь дараах үүргийг хүлээнэ:

3.2.1. Итгэлцлийн үйлчилгээний гэрээнд заасан хөрөнгийг итгэмжлэгдсэн өмчлөгчийн өмчлөлд шилжүүлэх;

3.2.2. Итгэмжлэгдсэн өмчлөгчид шилжүүлсэн хөрөнгийн талаар болон итгэлцлийн үйлчилгээг авахтай холбоотойгоор итгэмжлэгдсэн өмчлөгчөөс шаардсан бусад мэдээллийг үнэн зөв гаргаж өгөх;

3.2.3. Итгэлцлийн үйлчилгээний гэрээнд заасан хөлсийг итгэмжлэгдсэн өмчлөгчид төлөх;

3.2.4. Итгэлцлийн үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой итгэмжлэгдсэн өмчлөгчөөс гарсан зардлыг төлөх;

3.2.5. Итгэлцлийн үйлчилгээний гэрээнд хувь хүртэгчийг тодорхой тусгаж өгөх;

3.2.6. Итгэмжлэгч нь итгэмжилсэн хөрөнгийн эцсийн өмчлөгч байх ба хөрөнгийн гарал үүслийг итгэмжлэгдсэн өмчлөгчид шалгуулах

3.2.7. Итгэлцлийн үйлчилгээний гэрээнд зааснаас бусад тохиолдолд итгэмжлэгч нь итгэмжлэгдсэн хөрөнгийн ашиглалтын талаар аливаа зааварчилгаа өгөхгүй байх.

- 3.3. Итгэмжлэгчээс хүлээн авсан хөрөнгийг түүнтэй байгуулсан итгэлцлийн үйлчилгээний гэрээний дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах үүрэг хүлээсэн, итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд буюу “итгэмжлэгдсэн өмчлөгч” нь дараах эрхийг эдэлнэ:
- 3.3.1. Итгэлцлийн үйлчилгээний гэрээнд тусгасан үйлчилгээний төлбөрийг итгэмжлэгчээс шаардах;
  - 3.3.2. Итгэмжлэгдсэн мөнгөн хөрөнгийг ашиглахтай холбоотойгоор өмгөөлөгч болон бусад мэргэжлийн хүмүүсийг хөлслөх;
  - 3.3.3. Итгэлцлийн үйлчилгээний гэрээтэй холбоотой аливаа маргааныг шүүхэд нэхэмжлэл гаргах;
  - 3.3.4. Өөрийн өмчлөлийн хөрөнгөөр ББСБ нь итгэмжлэгч болон хувь хүртэгч байх.
- 3.4. Итгэмжлэгдсэн өмчлөгч нь дараах үүргийг хүлээнэ:
- 3.4.1. Итгэлцлийн үйлчилгээг авахаар хандсан этгээдэд өөрийн компанийн санхүүгийн байдал болон итгэлцлийн хөрөнгийг зарцуулах зориулалтын талаар үнэн зөв мэдээллийг гаргаж өгөх;
  - 3.4.2. Итгэлцлийн үйлчилгээний гэрээнд хөрөнгийг ямар үйл ажиллагаанд захиран зарцуулах талаар тусгах;
  - 3.4.3. Итгэмжлэгдсэн хөрөнгийн эх үүсвэрийг гагцхүү итгэлцлийн үйлчилгээний гэрээнд заасны дагуу зохицуулагч байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд захиран зарцуулах;
  - 3.4.4. Итгэмжлэгдсэн хөрөнгийн ашиглалтын талаар тодорхой, үнэн зөв бүртгэл, тайлан хөтлөх, шаардсан тохиолдолд итгэмжлэгчид гаргаж өгөх;
  - 3.4.5. Итгэмжлэгдсэн өмчлөгч нь хөрөнгө итгэмжлэх гэрээний үндсэн дээр итгэмжлэгчийн хөрөнгийг гэрээнд заасан хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулахтай холбоотой үүссэн үүргийг гуравдагч этгээдийн өмнө хариуцна.
  - 3.4.6. Итгэлцлийн үйлчилгээний гэрээнд нэгээс дээш хувь хүртэгчтэй байхаа заасан тохиолдолд үр шим хүртэх хувиас үл хамааран тэдэнд адил тэгш хандах;
  - 3.4.7. Итгэлцлийн үйлчилгээний гэрээнд өөрөөр заагаагүй бол бичгээр гаргасан хүсэлтийн дагуу итгэмжлэгдсэн хөрөнгө ашиглалттай холбоотой мэдээллийг хувь хүртэгчид гаргаж өгөх;
  - 3.4.8. Итгэлцлийн үйлчилгээний гэрээнд заасны дагуу хувь хүртэгчид ашиг олгох;
  - 3.4.9. Итгэмжлэгдсэн хөрөнгийн гарал үүслийг шалгах
  - 3.4.10. Итгэлцлийн үйлчилгээний дотоод журмыг боловсруулж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;
  - 3.4.11. Итгэмжлэгдсэн өмчлөгчийн гүйцэтгэх удирдлага нь тухайн ББСБ-ын цорын ганц хувь нийлүүлэгч биш тохиолдолд итгэлцлийн үйлчилгээгээр хүлээн авсан мөнгөн хөрөнгийн хэмжээ, итгэлцлийн үйлчилгээний гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлагын талаарх хувь нийлүүлэгчдэд мэдэгдэх;
- 3.5. Итгэмжлэгдсэн мөнгөн хөрөнгийн үр шимийг хүртэхээр итгэлцлийн үйлчилгээний гэрээнд заасан иргэн, хуулийн этгээд буюу “хувь хүртэгч”-ийн эрх, үүргийг итгэлцлийн гэрээгээр тодорхойлох ба итгэмжлэгч өөрийн эрх, үүргээс итгэмжлэл олгосны үндсэн дээр хувь хүртэгчид шилжүүлж болно.

## ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 4.1. СЗХ-оос итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан этгээд нь итгэмжлэгчийг татах зорилгоор олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах, сурталчилгаа явуулахдаа дараах зарчмыг баримтална.
  - 4.1.1. Бизнестээ харилцагч татахын тулд бэлэг эсвэл бусад урамшуулал санал болгохгүй;
  - 4.1.2. Үр шимийн хувь хэмжээг зар сурталчилгаанд ашиглахгүй байх;
  - 4.1.3. Харилцагчийг зээлээр хөрөнгө олж авах, тухайн хөрөнгийг итгэлцлийн хөрөнгө болгон шилжүүлэхийг ятгахгүй;
  - 4.1.4. Өмнөх үр дүн, гүйцэтгэлээ хэтрүүлэн дөвийлгөн сурталчлах, мөн худал хуурмаг, залилан мэхлэх, нууц мэдээлэл задруулах, төөрөгдөл бий болгох үйлдэл гаргахгүй.
  - 4.1.5. Зар сурталчилгаа, сурталчилгааны материалууд нь СЗХ-оос олгосон итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг итгэлцлийн үр шимийн үнэ цэний баталгаа болгон ашиглахгүй байх;
  - 4.1.6. Зар сурталчилгаа, сурталчилгааны материалууд нь хөрөнгийн үндсэн дүнгийн найдвартай байдал эсхүл үр шим олно гэдэгт баталгаа гаргасан мэтээр бусдыг төөрөгдүүлэхгүй байх;
  - 4.1.7. Харилцагчийг төөрөгдүүлж болзошгүй нэрсийг ашиглахгүй байх;
  - 4.1.8. Зар сурталчилгаа, сурталчилгааны материалд ашигт ажиллагаа болон эрсдэлийг тэнцвэртэйгээр харуулсан байх бөгөөд СЗХ-нд ирүүлсэн өргөдлийн баримт бичгийн агуулгатай зөрчилдөх аливаа бичвэр, загварыг ашиглахгүй байх;
  - 4.1.9. Зар сурталчилгаа, сурталчилгааны материал нь аливаа хууль, журам болон итгэлцлийн гэрээний агуулгыг зөрчихгүй байх.
- 4.2. Итгэмжилсэн мөнгөн хөрөнгийг зохицуулагч байгууллагаас зөвшөөрөл аваагүй бусад санхүүгийн үйл ажиллагаанд зарцуулах;
- 4.3. Итгэмжлэгдсэн өмчлөгч нь итгэмжлэгдсэн мөнгөн хөрөнгийг итгэлцлийн үйлчилгээний гэрээгээр тогтоосон нөхцөлийг зөрчиж хувь хүртэгчийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглах;
- 4.4. Итгэлцлийн үйлчилгээний гэрээ байгуулах хүсэлтэй итгэмжлэгчийн санал болгож байгаа нөхцөл, шаардлагыг итгэмжлэгдсэн өмчлөгчийн эрх ашигт албадан нийцүүлэх аливаа оролдлого хийх;

### ТАВ. ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

- 5.1. Хорооноос итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан банк, ББСБ болон түүнд итгэл хүлээлгэсэн итгэмжлэгч харилцан тохиролцсоны үндсэн дээр итгэлцлийн үйлчилгээний гэрээг байгуулна.
- 5.2. Итгэлцлийн үйлчилгээний гэрээг Иргэний хуулийн 406 дугаар зүйлд заасны дагуу зөвхөн бичгээр байгуулна.
- 5.3. Итгэлцлийн үйлчилгээний гэрээнд дараах зүйлийг заавал тусгасан байна:
  - 5.3.1. Итгэмжлэгч нь иргэн бол түүний овог нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, хаяг, утас;
  - 5.3.2. Итгэмжлэгч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний болон регистрийн дугаар, хаяг, утас;
  - 5.3.3. Итгэмжлэгдсэн өмчлөгчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний болон регистрийн дугаар, хаяг, утас;

- 5.3.4. Хувь хүртэгч нь иргэн бол тэдгээрийн овог нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, хаяг, утас;
- 5.3.5. Хувь хүртэгч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний болон регистрийн дугаар, хаяг, утас;
- 5.3.6. Итгэмжлэгчээс итгэмжлэгдсэн өмчлөгчид шилжүүлэх мөнгөн хөрөнгийн хэмжээ;
- 5.3.7. Итгэмжлэгдсэн хөрөнгийг захиран зарцуулах зориулалт;
- 5.3.8. Гэрээний хугацаа;
- 5.3.9. Итгэлцлийн үйлчилгээгээр олохоор төлөвлөж буй үр шим,
- 5.3.10. Хувь хүртэгчийн хувь хүртэх үр шим, хэмжээ;
- 5.3.11. Итгэлцлийн үйлчилгээ үзүүлсний төлөө гарах зардал, түүнийг хэрхэн шийдвэрлэх;
- 5.3.12. Итгэлцлийн үйлчилгээ үзүүлсний төлөө итгэмжлэгдсэн өмчлөгчийн авах хөлсний хэмжээ;
- 5.3.13. Итгэмжлэгчийг итгэлцлийн үйлчилгээний явц болон холбогдох мэдээллээр хэрхэн хангах;
- 5.3.14. Итгэлцлийн үйлчилгээнд оролцогч талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлага;
- 5.3.15. Итгэлцлийн үйлчилгээний гэрээ дуусгавар болгох нөхцөл.

#### ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

- 6.1. Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээнээс үүссэн аливаа эрсдэлийг СЗХ хариуцахгүй болно.
- 6.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---